



**“МОНГОЛ БОЛОН ТӨВ АЗИ” (XIX ЗУУНЫ СҮҮЛЧ, XX ЗУУНЫ  
ЭХЭН) ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН  
УДИРДАМЖ**

**Зохион байгуулагч: МУБИС-ийн Монгол судлалын төв**

**Хамтран зохион байгуулагч: Монгол улсын Монгол судлалыг дэмжих сан**

**Монгол судлалын үндэсний зөвлөл**

**Хурал 2015 оны 6 сарын 19-21-нд Улаанбаатар хотноо, МУБИС дээр болно.**

***Хурлын зорилго, хамрах хүрээ:***

Шведийн алдарт аялагч-эрдэмтэн, зураач Свэн Хединий мэндэлсний 150 жилийн ой, түүний аялалын багийнхны XIX зууны сүүлч, XX зууны эхээр Төв Азид, тухайлбал монгол нутагт хийсэн аяллын дурсгалд зориулан, тухайн үеийн монголын түүх, үндэстэн ястны амьдрал, аж ахуй, хэл, соёл, шашин шүтлэгийн талаар хийсэн судлаачдын судалгааны ажилтай танилцан, хэлэлцүүлэг зохион байгуулахад оршино.

Энэхүү хурлыг зохион байгуулснаар гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдыг нэгтгэх, тэдний хооронд ажил хэргийн холбоо тогтоох боломж олгохыг зорьж байна. Хурлын үеэр Свэн Хединий намтар, зургийн үзэсгэлэн мөн “Монгол туургатан” оюутны урлагийн тоглолт зэрэг үйл ажиллагаа зохиогдоно.

***Хуралд оролцогчид нь илтгэлээ:***

Монгол, Англи, Орос хэлээр тавьж болно.

***Хуралд оролцогчдын зардал:***

Хуралд оролцох гадаадын эрдэмтэд, зочид төлөөлөгчид замын зардал болон Улаанбаатарт байх буудлын зардлаа өөрсдөө хариуцна. Монголоос оролцох илтгэгчид 80 мянган төгрөгийн хураамж төлнө.

***Материал хүлээн авах хугацаа:***

Илтгэлийн хураангуйг\* хавсралт хүснэгт (дараагийн хуудаснаас дэлгэрэнгүй тайлбарыг уншина уу) -ээр 2015 оны 4 сарын 1-ний дотор хүлээн авна.

Хурлын удирдамж, эрдэм шинжилгээний ажлын шаардлагыг хангасан илтгэлийг бүрэн эхээр нь 2015 оны 5 сарын 20-ний дотор хүлээн авна. Хуралд оролцох хүсэлт, илтгэлийн хураангуй болон эх хувийг [a\\_oyuntungalag@yahoo.com](mailto:a_oyuntungalag@yahoo.com), [unuroyun@yahoo.com](mailto:unuroyun@yahoo.com) цахим хаягаар ирүүлнэ үү.

Хурлын дэлгэрэнгүй мэдээллийг [a\\_oyuntungalag@yahoo.com](mailto:a_oyuntungalag@yahoo.com), [unuroyun@yahoo.com](mailto:unuroyun@yahoo.com) цахим хаяг мөн 323687, 99133363, 99154938 утсаар холбогдон авна уу.

### Хавсралт

#### \*Хуралд оролцогчдын бүртгэл, мэдээллийн хүснэгт

- “МОНГОЛ БОЛОН ТӨВ АЗИ” (XIX зууны сүүлч, XX зууны эхэн) ОУ-ын ЭШХ-д оролцохыг хүсэгчид доорх хүснэгтэд өөрийн товч мэдээллийг бичиж, илтгэлийн сэдэв, хураангуйн хамт 2015 оны 4 сарын 1-ний дотор [a\\_oyuntungalag@yahoo.com](mailto:a_oyuntungalag@yahoo.com), [unuroyun@yahoo.com](mailto:unuroyun@yahoo.com) цахим хаягаар явуулна.
- Илтгэлийн сэдэв, хураангуйг (200-300 үгэнд багтаана) Times New Roman үсгийн фонтоор, 12 үсгийн хэмжээтэй бичнэ.
- Илтгэлийн хураангуй, мэдээллийг хүлээн авсны дараа хариу захидал явуулна.

#### МЭДЭЭЛЛИЙН ХҮСНЭГТ

Нэр:	Овог:
Улс, аймаг, хот:	
Ажлын газар, байгууллага, сургууль:	
Албан тушаал:	Эрдмийн зэрэг, цол:
Факультет, тэнхим:	Мэргэжил, судалгааны чиглэл:
Цахим хаяг, утас:	

#### ИЛТГЭЛИЙН ХУРААНГУЙ (200-300 үгэнд багтаана)

--